



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 31

Дугаар 02/24

Жаргалант сум

┌ “Соёлыг дэмжих” хөтөлбөр болон ┐
хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49,1 дэх хэсгүүдийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Соёлыг дэмжих” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай


2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Засаг дарга (Л.Учрал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
02/11 тогтоолын нэгдүгээр хавсралт



“СОЁЛЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨР

НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Тус хөтөлбөрийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн нийгэм эдийн засгийг 2024-2028 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Жаргалант сумыг 2024-2028 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгийн үзэл санаа зарчимд үндэслэн боловсруулав.

“Соёлыг дэмжих” хөтөлбөр нь Жаргалант сумын Засаг даргын 2024-2028 онд үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан соёлын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааг бүхэлд нь тусгасан баримт бичиг бөгөөд мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн салшгүй хэсэг мөн.

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ

2.1.Хөтөлбөрийн зорилго

2.1.1.“Соёлыг дэмжих” хөтөлбөрийн /цаашид “Хөтөлбөр” гэх/ зорилго нь Жаргалант сумын соёл мэдээллийн төв болон иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон соёлын таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

2.2.Хөтөлбөрийг зорилтууд:

- 2.2.1.Соёлын үйлчилгээг үзүүлж байгаа абан хаагчдын чадварыг нэмэгдүүлэх
- 2.2.2.Өв соёлыг орчин үеийн шийдэлтэйгээр түгээн дэлгэрүүлэх
- 2.2.3.Байгууллагын гадна дотор, тохижилт /бүтээн байгуулалт/
- 2.2.4.Иргэдэд чиглэсэн соёл урлаг, уран сайхан

2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

- 2.3.1.Хөтөлбөр нь иргэдийн соёлын хэрэгцээ шаардлага, эрэлт хэрэгцээ, итгэл үнэмшилд тулгуурлах
- 2.3.2.Соёлын тухай хууль болон холбогдох баримт бичиг, хөтөлбөртэй нийцсэн байх
- 2.3.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй уян хатан, чанартай байх
- 2.3.4 Төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоо, иргэд, сонирхогч бүх талын дэмжлэгт түшиглэх
- 2.3.5 Мэдээлэл, харилцааны технологийн ололт амжилтыг ашиглах

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

“Соёлыг дэмжих” хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

- 4.1.1.Улсын болон орон нутгийн төсөв
- 4.1.2.Төрийн бус байгууллагуудын дэмжлэг, хандив.
- 4.1.3.Гадаад дотоодын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр

4.1.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн нийгмийн хариуцлагын хүрээн дэх үйл ажиллагаа, хандив, дэмжлэг.

4.1.5.Иргэд, олон нийт, албан байгууллагын хандив зэргээс бүрдэнэ.

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



5.1.Хөтөлбөрийг дараах байдлаар зохион байгуулна.

5.1.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж хэрэгжилтийн явц үр дүнг хагас жилээр сумын Засаг даргад тайлагнаж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж Засаг даргаар батлуулж үүрэг чиглэл авч ажиллана.

5.1.2.Ажлын хэсэг нь хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн орчин бүрдүүлэх, иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо, уялдаа холбоог хангах, хөтөлбөрийн улирлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүжилтийн асуудлыг Сумын ИТХ, орон нутгийн Засаг захиргаа, байгууллагын захиргаанд уламжлан шийдвэрлүүлэх асуудлыг хариуцна.

5.1.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь хөрөнгө оруулалт, сургалт, туршлага судлах, иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, уламжлалт соёлыг хадгалах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх биет болон биет бус өвлөн тээгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг нээн илрүүлэх, тэднийг сурталчлах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлбэрээр зохион байгуулагдана.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖСЭНЭЭР ГАРАХ ҮР ДҮН

6.1.Жил бүр уламжлал болгон урлаг соёлын томоохон тэмцээн уралдааныг зохион байгуулснаар иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлж, соёлын үйл ажиллагааг илүү том цар хүрээтэйгээр илрүүлэх боломжтой.

6.2.Соёлын байгууллагын чанар хүртээмжийг сайжруулснаар иргэдийн ая тухтай үйлчилгээ авах орчин бүрдэнэ.

6.3.ХБИ-д үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэх.

6.4.Номын санг орчин үеийн шинэлэг стандартад нийцүүлэн тохижуулах, номын фондыг нэмэгдүүлэх ингэснээр иргэдийн Уншлага-Үйлчилгээ нэмэгдсэн байна.

6.5.Хоёр жилд нэг удаа төрийн болон хувийн хэвшил, багуудын дунд соёл урлагийн идэвх оролцоог нэмэгдүүлэх бага наадам зохион байгуулах. Албан хаагчдын урлагийн авьяасыг чадварын нээн хөгжүүлэх.

6.6.Малчид, Тариаланчид дуулж байна уралдааныг 2 жилд нэг удаа зохион байгуулж тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх чөлөөт цагийг

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ


7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийн биелэлтээр гаргана.

7.2.Хөтөлбөрийн төлөвлөгөөг жил бүр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж 12 дугаар сард төлөвлөгөөний гүйцэтгэлийг тайлагнана.

7.3.Хөтөлбөрийн үнэлгээг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн 2025-2028 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөний биелэлтийн дундаж гүйцэтгэлээр 4 жилийн гүйцэтгэлийг дүгнэнэ.

7.4.Шаардлагатай тохиолдолд хааж мөн засаж сайжруулж болно.

**НАЙМ.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зорилтууд	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Шаардагдах санхүүжилтийн хэмжээ,эх үүсвэр	Хүрэх үр дүн
		2025	2026	2027	2028		
НЭГ:СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЖ БАЙГАА АЛБАН ХААГЧДЫН ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ	1.1.Соёлын төвийн албан хаагч нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах						Төлөвлөгөөт болон хэрэгцээт сургалтад бүх ажилчдыг хамруулах, сайн ажиллаж байгаа ажилтныг их дээд сургуульд хэрэгцээт чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, дэмжиж хөгжүүлэх
	1.2.Ардын хөгжим, уртын дууны багш төвтэй сургалт авах						Бие даасан уран бүтээлчидтэй болох
	1.3.Улс, бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд өөрөө болон дугуйлангийн сурагчдыг амжилттай оролцуулсан багш, сурагчдад мөнгөн урамшуулал олгох						Багш, дугуйлангийн сурагчдын идэвх оролцоо нэмэгдэх.
	1.4.Эрүүл мэндийн үзлэг оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах, төлбөрийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх						Албан хаагчдыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.
ХОЁР: ӨВ СОЁЛЫГ ОРЧИН ҮЕИЙН ШИЙДЭЛТЭЙГЭЭР ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ	2.1.Үлээвэр найрал хөгжмийн баг, застав байгуулах						Иргэд, уран сайханчдыг нээж илрүүлэх, хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх.
	2.2.Бүжиг урлаг, дуу урлаг, хөгжим урлаг, уран бичлэг, дүрслэх урлагийн үзэсгэлэн зэрэг төрлүүдээр бүс нутгийн, олон улсын чанартай уралдаан тэмцээн, үзэсгэлэн болон худалдаанд оролцох үед мөн өв соёлын өвлөн уламжлагч, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх						Биет болон биет бус өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, суманд амьдарч буй өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, шагнаж урамшуулах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж урамшуулан брэнд бүтээгдэхүүн шалгаруулах
	2.3.Өв соёлтой холбоотой нэвтрүүлэг, контент, дүрс бичлэг хийж сумын үзэсгэлэнт газрууд болон дурсгалт газруудаар дүрсжүүлж тайлбарлан архивлахад шаардлагатай техник хэрэгсэл осма, дрон, гэрэл зургийн аппарат						Биет болон биет бус өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, суманд амьдарч үлгэр, домог, түүх ярьдаг иргэдийг нээн илрүүлж дүрсжүүлж архивлах. Улмаар ном хэвлүүлэн гаргаж түгээн дэлгэрүүлэн сурталчилж Жаргалант сумын талаарх судалгааг нэмэгдүүлэх
3.1.Он солигдох цаг мөчид гадаа талбайн эвэнт зохион байгуулах	3.1.Он солигдох цаг мөчид гадаа талбайн эвэнт зохион байгуулах						Иргэдийг он солигдох цаг мөчид гадаа талбайд цуглуулах, урлаг уран сайхнаар үйлчлэх
	3.2.Соёл мэдээллийн төвийн зааланд агааржуулалтын системтэй болох						Олноор цугларсан үед хүчил төрөгчийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх
	3.3.Багтаамж сайтай зориулалтын хувцас өлгөх өрөө болон өлгүүртэй болох						Иргэд ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ. Соёлд суралцана.

	3.4. “Урлаг зал”-ны үзэгчийн сандлыг давхар болгон шинэчлэх					Үзэгчдийн үзвэр үзэх ая тух бүрдэнэ. Хүртээмж нэмэгдэнэ.
	3.5. Номын санд кофе шоп ажиллуулах, тав тухтай орчин бүрдүүлэх					Номын санд тав орчин бүрдсэнээр үйлчлүүдэгчийн тоо нэмэгдэж үйлчилгээний сэтгэл ханамж дээшилнэ. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх тохилог орчин бүрдэнэ.
	3.6. Тайз руу харсан нэмэлт контрол чанга яригчтай болох					Соёл урлагийн үйл ажиллагааны үеэр дуучид руу чиглэсэн нэмэлт яригч байвал илүү алдаагүй, чанартай үйл ажиллагааг иргэдэд хүргэнэ.
	3.7. Соёл мэдээллийн төвийн үүдэн хэсгийг засварлах, налуу шат хийх, гэрэлтүүлэг нэмэх					Иргэдэд үйлчлэх үйлчилгээний чанар хүртээмж, ая тух сайжирна. ХБИ-д орж гарахад саад учруулахгүй байх.
	3.8. Лед дэлгэцийн 2 талд босоо нарийн лед дэлгэцтэй болох					Тоглолт арга хэмжээний үед тайзны өнгө үзэмж сайжирна,
ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ГАДНА ДОТОР, ТОХИЖИЛТ /бүтээн байгуулалт/	3.9. Зөөврийн тайзтай болох 4x8 хэмжээтэй					Зөөврийн тайзтай болсноор гадаа томоохон тоглолт, шоу арга хэмжээ зохион байгуулах түрээсийн үйлчилгээ үзүүлж орлого нэмэгдэх боломж бүрдэнэ
	3.10. Тайзны арын бор хөшгийг солих					Тайзны бор хөшгийг цагаан хөшгөөр сольсноор өнгө үзэмж сайжирна.
	3.11. Давхар тайзан дээр лед дэлгэцний арын хамгаалалт 11:90см хэмжээтэй, вакум ерөө тоглолтын хувцас, гутал, жижиг хэрэгсэл, ном хадгалах шкаф өргөн нь 2м урт нь 4,90 өндөр 2,70см хэмжээтэй байна.					Дугуйлангийн сурагчдын гутал, хувцас, жижиг хэрэгсэл, ном хадгалах ерөөтэй болж эмх цэгц бий болгох.
	3.12. Уран сайханчдын хувцас өлгөх өлгүүртэй болох					Уран сайханчид хувцсаа ширээ болон цонхны тавцан дээр тавьдаг зориулалтын өлгүүргүй учир өлгүүрийн асуудал шийдэх.
	3.13. Дохиолол хамгаалалттай болох					Харуулын батлагдсан орон тоо байхгүй тул ажил дууссаны дараа цоожтой байдаг энэ хугацаанд эрсдэл гарах магадлал өндөр байдаг учир эрсдэлээс урьдчилан сэргийлэх
	3.14.1 давхрын цонхыг хамгаалалттай болох					Ажил дууссаны дараа цоожтой байдаг энэ хугацаанд эрсдэл гарах магадлал өндөр байдаг учир эрсдэлээс урьдчилан сэргийлэх
	4.1. Урлагийн хувцас, бүжгийн хувцастай болох					Урлаг уран сайхны үйлчилгээ үзүүлэхэд өнгө үзэмж сайжирна.
ДӨРӨВ: ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН УРЛАГ, УРАН САЙХАН	4.2. Урлагийн бага наадам					2 жилд нэг удаа төрийн болон хувийн хэвшил, багуудын дунд соёл урлагийн идэвх оролцоог нэмэгдүүлэх
	4.3. Малчид дуулж байна					Монголын уламжлалт Сар шинийн баярын үеэр малчдын дунд зохион байгуулах
	4.4. Тариаланчид дуулж байна					“Алтан намар” арга хэмжээний үеэр уламжлал болгон явуулах
	4.5. Орчин үеийн караокены төхөөрөмж					Иргэдийн дунд болон баяр ёслолын үед уралдаан тэмцээн зохион байгуулах. Орчин үеийн шинэ дууг тухайн бүрт нь шинэчлэн оруулж байх.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны
12 дугаар сарын 31-ний ээлжит III хуралдааны
09/24 тогтоолын хоёрдугаар хавсралт

СОЁЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.12.20

Жаргалант сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Санхүүж илтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хариуцагч
					Он	Түвшин		
Зорилт 1-ийн хүрээнд соёлын үйлчилгээ үзүүлж байгаа албан хаагчдын чадварыг нэмэгдүүлэх.								
1	Соёлын төвийн ажилтан нарын мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах	-	СМТ төсөв	Хамрагдсан хүний тоо	-	-	Төлөвлөгөөт болон хэрэгцээт сургалтад бүх ажилчдыг хамруулах, сайн ажиллаж байгаа ажилтныг их дээд сургуульд хэрэгцээт чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, дэмжиж хөгжүүлэх	Соёл мэдээллийн төв
2	Ардын хөгжим, уртын дууны багш төвтэй сургалт авах	-	СМТ төсөв	Хамрагдсан хүний тоо	-	-	Бие даасан уран бүтээлчидтэй болох	Соёл мэдээллийн төв
3	Эрүүл мэндийн үзлэг оношилгоонд нэгдсэн журмаар хамруулах, төлбөрийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх	-	СМТ төсөв	Хамрагдсан хүний тоо	2023	7 албан хаагч эрт илрүүлэгт хамрагдсан	Албан хаагчдыг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх.	Соёл мэдээллийн төв
Зорилт 2-ийн хүрээнд дараах үйл ажиллагаа зохион байгуулна. /иргэдэд чиглэгдсэн/								
4	Соёл мэдээллийн төвд агааржуулалтын системтэй болох	20.0	ОНТ	Ажлын гүйцэтгэлээр	-	-	Иргэд ая тухтай болж боломж үйлчлүүлэх бүрдэнэ.	ЗДТГ,

10	1 давхрын цонхны хамгаалалттай болох	-	-	Хэрэгжилтийн хувь	2025	-	Ажил дууссаны дараа цоожтой байдаг энэ хугацаанд эрсдэл гарах магадлал өндөр байдаг учир эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Соёл мэдээллийн төв
Зорилт 3-ийн хүрээнд иргэдэд чиглэсэн урлаг, уран сайхан								
11	Үндэсний спортын хувцас хэрэглэл болон бүжгийн хувцастай болох	20.0	ОНТ	Тоо ширхэг	-	-	Урлаг уран сайхны үйлчилгээ үзүүлэхэд өнгө үзэмж сайжирна.	Соёл мэдээллийн төв
12	Малчид, тариаланчид дуулж байна уралдааныг зохион байгуулах	5.0	ОНТ	Хамрагдсан иргэдийн тоо	2023	Зохион байгуулсан	Зохион байгуулсан байна.	Соёл мэдээллийн төв
13	Тоног төхөөрөмж худалдан авах	15.0	ОНТ	Тоо	2023		Ажлын гүйцэтгэлээр	ЗДТГ Соёл мэдээллийн төв
14	Утаа гаргагч, гэрэлтүүлэг нэмэх	15.0	ОНТ	Хэрэгжилтийн хувь	-	-	Баяр ёслол хүлээн авалтад ашиглах	Соёл мэдээллийн төв
Зорилт 14 арга хэмжээ 111.0 сая төгрөг								